

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ 2025

Агуулга

1. Мэндчилгээ
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар
3. Хурлаар хэлэлцэх асуудал
4. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацаа
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах шийдвэр
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг
7. Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой материал
 - “Эм Жи Эл Акуа” ХК-ийн 2024 жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцүүлж батлах
 - Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг танилцуулах
 - Компанийн ногдол ашгийн бодлого, 2025 оны ногдол ашгийн шийдвэрийг танилцуулах
 - ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
 - ТУЗ-ийн 2025 оны төсөв батлах
8. Хурлаас гарах тогтоолын төслүүд
9. Саналын хуудасны загвар
10. Тэмдэглэл

МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт Хувьцаа эзэмшигчид ээ,

2024 он “Эм Жи Эл Акуа” ХК-ийн хувьд хөгжил дэвшил бүхий түүхэн жил байлаа.

Voyage брэнд нь нийт цэвэр усны зах зээлийн 43%-ийг дангаар эзэлж түүхэн дэх хамгийн өндөр зах зээлийн тэлэлтээ хийж байна.

Борлуулалт тоо ширхэгээр 25.1 сая ширхэг борлуулж өмнөх оноосоо +11% өсөж, мөнгөн дүнгээр 23.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноосоо +18% өсөлттэй байна.

Компанийн нийт харилцагчийн тоо 5443 хүрч өмнөх оноосоо +8% өссөн үзүүлэлттэй байна. Мөн орон нутгийн гэрээт харилцагчийн тоо 154 хүрч гэрээт харилцагчийн хамтран ажилладаг 3709 харилцагчдад үйлчилж байна.

Үйлдвэрлэл 20.8 сая ширхэг үйлдвэрлэж өмнөх оноосоо +7% өссөн гүйцэтгэлтэй байна. Түгээлтийн алба нийт давтагдсан тоогоор 89.784 харилцагчдад 28.895 тонн ус түгээж өмнөх оноос +15% өссөн.

Компани нийт 193 ажиллах хүчинтэй ажиллаж төлөвлөгөөнөөсөө 89%-ийн гүйцэтгэлтэй байна.

Харилцагч руу чиглэсэн хөтөлбөр 6 удаа амжилттай хэрэгжүүлсэн байна. Хэрэглэгч, харилцагч руу чиглэсэн “БАЙРТАЙ БӨГЛӨӨ” урамшуулалт хөтөлбөрийг 2 сар 18 хоногийн турш хэрэгжүүлсэн бөгөөд тус хөтөлбөр нь Монгол Улсын шингэн хүнсний салбарын хамгийн том бэлэгтэй, хамгийн олон хэрэглэгч оролцсон хөтөлбөр болж хэрэглэгчдийн анхаарлыг татан амжилттай өрнөсөн. Үүгээр бид зөвхөн урамшуулалт хөтөлбөр явуулах төдий бус, Итгэл төгс хэрэглээний чанар стандартыг түгээн дэлгэрүүлэн Voyage брэндийн үнэ цэнийг олон нийтэд танилцуулж амжилтаа ахиулсан он байлаа.

Хамтын удирдлага, хамтын өсөлт, сайн засаглал, тогтвортой хөгжлийн төлөө хамтдаа байгаа та бүхэндээ баярлалаа.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**

С.АЛТАНГУЯА

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын
12-ны өдрийн Т/38 дүгээр тогтоолын
Хавсралт №1*

“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Эм Жи Эл Акуа” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04-р сарын 23-ны өдөр 10:00 цагт agm.mn холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр хуралдана.

Хурал зохион байгуулах газрын хаяг: “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн <https://agm.mn/> цахим системээр

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр:
2025 оны 04-р сарын 04-ний өдөр

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. “Эм Жи Эл Акуа” ХК-ийн 2024 жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ -ийн дүгнэлтийг хэлэлцүүлж батлах
2. Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг танилцуулах
3. Компанийн ногдол ашгийн бодлого, 2025 оны ногдол ашгийн шийдвэрийг танилцуулах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ-ийн 2025 оны төсөв батлах

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд өөрийн үйлчлүүлдэг Үнэт цаасны компаниуд, компанийн байранд танилцах боломжтой.

Аж ахуй нэгжийг төлөөлөн хуралд орлох хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл урьдчилан хурал зохион байгуулах комисстой холбогдон тодруулага, мэдээлэл авна уу.

Холбоо барих: 77045555, 89998851, 80498649
Мэйл хаяг: investor@mglacqua.mn

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Хурлаар хэлэлцэх асуудал

- “Эм Жи Эл Акуа” ХК-ийн 2024 жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцүүлж батлах
- Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг танилцуулах
- Компанийн ногдол ашгийн бодлого, 2025 оны ногдол ашгийн шийдвэрийг танилцуулах
- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- ТУЗ-ийн 2025 оны төсөв батлах

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлд нэр дэвшигчдийн танилцуулга
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоол, шийдвэрийн төсөл
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд өөрийн үйлчлүүлдэг Үнэт цаасны компаниуд, компанийн байранд танилцах боломжтой.

Холбоо барих: 77045555, 89998851, 80498649
Мэйл хаяг: investor@mglacqua.mn

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Ээлжит хурал хуралдуулах шийдвэр

“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 12

№ Т/38

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 59.1, 59.4, 60.1 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Эм жи эл акуа” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр 10:00 цагт <https://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - “Эм Жи Эл Акуа” ХК-ийн 2024 жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ -ийн дүгнэлтийг хэлэлцүүлж багтах
 - Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг танилцуулах
 - Компанийн ногдол ашгийн бодлого, 2025 оны ногдол ашгийн шийдвэрийг танилцуулах
 - ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
 - ТУЗ-ийн 2025 оны төсөв батлах
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-ийн дагуу баталж, мэдээг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сонин, олон нийтийн телевизийн мэдээгээр хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисс-т даалгасугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт №2-р баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-р баталсугай. Хавсралт №3-д заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд өөрийн үйлчлүүлдэг Үнэт цаасны компаниуд, компанийн байранд танилцах эрхтэй болохыг дурьдсугай.
7. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах саналын хуудасны загварыг Хавсралт №4-р баталсугай.
8. Хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид урьдчилсан саналын хуудсыг бөглөн ирүүлэх боломжтой ба өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компаниар дамжуулан хүргүүлэх, эсхүл “Эм жи эл акуа” ХК-ийн байранд биеэр ирж өгөх боломжтой. Хувьцаа эзэмшигчээс ирүүлсэн урьдчилсан саналын хуудсыг хүлээн авах эцсийн хугацаа 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 10:00 цаг байхаар тогтсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Б.Бат-Оргил /Эм жи эл агуа ХК, гүйцэтгэх захирлын орлогч/, зохион байгуулах комиссын гишүүдэд Д.Бат-ирээдүй /Эм жи эл агуа ХК, Ерөнхий нягтлан бодогч/, Б.Дашзэвэг /Эм жи эл агуа ХК, Түгээлтийн албаны дарга/, Ш.Отгонцэцэг /Эм жи эл агуа ХК, Маркетингийн албаны дарга/ нарыг тус тус томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар С.Санасэр /Эм жи эл агуа ХК, ТУЗ хараат бус гишүүн/.
- Тооллогын комиссын даргаар: С.Дөлгөөн /БиДиСЕК ҮЦК ХК-ийн Хөрөнгө оруулалтын албаны захирал/, гишүүдээр: Г.Намхайдорж /Эм жи эл агуа ХК, ТУЗ НБД/, Г.Энхжин /БиДиСЕК ҮЦК ХК-ний Харилцагчийн албаны мэргэжилтэн/, М.Оюунсүвд /БиДиСЕК ҮЦК ХК-ний Харилцагчийн албаны мэргэжилтэн/ нарыг тус тус томилсугай

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



С. АЛТАНТУЯА

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

№		Хугацаа	Танилцуулах
1	Хурлын ирцийг бүртгэх	00:00-10:00	Тооллогын комисс
2	Хурлын ирцийг мэдээлэх	10:00-10:05	Тооллогын комисс
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	10:05-10:10	Хурлын дарга
4	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах	10:10-11:00	Хурлын дарга, Зохион байгуулах комисс
5	Хувьцаа эзэмшигчид үг хэлэх, санал гаргах	11:00-11:15	Хурлын дарга
6	Санал хураалт	11:15-11:35	Тооллогын комисс
7	Хурлын завсарлага	11:35-11:55	Зохион байгуулах комисс
8	Тооллогын комисс санал хураалтын нэгдсэн дүнг гаргаж, комиссын дарга дүнг танилцуулах	11:55-12:05	Тооллогын комисс
9	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	12:05-12:15	Хурлын дарга
10	Хурлыг хаах	12:15-12:20	Хурлын дарга

Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой мэдээлэл:



ЭМ ЖИ ЭЛ АКУА ХК-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, Эм Жи Эл Акуа ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.21.12-н хүрээнд Эм Жи Эл Акуа ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг 2025 оны 03-р сарын 19-ны ТУЗ-ийн хуралдаанд хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Стратеги: Эм Жи Эл Акуа ХК нь 2024 оны 5 сарын 15-21 хооронд нийт 327,555,616 ширхэг хувьцаа гарган, хувьцааныхаа нэгжийн үнийг 174 төгрөгөөр арижаалж, үүнийхээ 26.73 хувийг олон нийтэд санал болгон 5 сарын 31-ны өдөр IPO-оор 15,234,677,184 төгрөг татан төвлөрүүлсэн нь 2024 оны онцлох үйл явдал байлаа. IPO хийж хөрөнгө татан төвлөрүүлэхийн үндсэн зорилгыг зөвхөн орон нутагт салбар үйлдвэр барих гэсэн утгаар ойлгож үл болно. Эм Жи Эл Акуа ХК нь 2015 оноос хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн автоматжуулах, бүтээгдэхүүний төрөлжилт, шинэ брэндийг хөгжүүлэх, байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийг дэмжих, логистик болон түгээлтийн сүлжээг сайжруулах, чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх зэрэг олон стратегиудыг хэрэгжүүлж ирсэн. Цаашид ч гэсэн эдгээр стратегиуд тогтвортой үргэлжлэх ба IPO хийснээр хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээх үүрэг хариуцлага өндөрсөж, санхүүгийн тогтвортой байдал бэхжин, сайн засаглалын удирдлага доор компанийн өсөлтийг дараагийн шинэ үе шатанд шилжлээ гэсэн утгаар ойлгох нь зохистой юм.

Зах зээлд эзлэх хувь: Монгол улсын нэг хүнд ногдох савласан усны хэмжээ 2013 онд 13.7 литр байсан бол жилд дунджаар 9.3 хувиар өссөөр 2024 онд 36.4 литр хүрчээ. Үүнийг 2024 оны нийт хүн амын тоогоор авч үзэхэд Монгол улсын савласан цэвэр усны зах зээл 128,875.5 мянган тонн литр байна. Эм Жи Эл Акуа ХК нь 2024 онд 25,034,337 ширхэг буюу 36,302.4 мянган литр ус үйлдвэрлэсэн нь савласан цэвэр усны зах зээлийн 28.2 хувийг эзлэх хэмжээнд хүрчээ. Усны эрэлт хэрэгцээ жил бүр өсөхийн хирээр усны зах зээл тэлсээр байгаа ба тус зах зээлд MGL Aqua, MCS Coca Cola, GEM зэрэг компаниуд томоохон байр суурь эзэлдэг. Эм Жи Эл Акуа ХК-ий борлуулалтын орлогыг дүнгээр нь авч үзэхэд зах зээлд эзлэх хувь 2023 онд 39 хувь, 2024 онд 43 хувьд хүрснээр зах зээлд эзлэх хэмжээгээ 4 нэгж хувиар тэлсэн байна.

Борлуулалтын орлого: Эм Жи Эл Акуа компани нь борлуулалтын орлогын сувгуудаа томоохон бүсүүдэд, сүлжээ супермаркетуудад, бөөний худалдааны төвүүдэд, задгай худалдаа захуудад, томоохон бүс доторх зах зээлүүдэд, ресторан, кафе, папуудад гэж ангилдаг. Эдгээр борлуулалтын орлогын сувгуудад 2024 онд түгээлтэд 74, борлуулалтад 52 нийт 126 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа нь нийт ажиллах хүчний 61.4 буюу дийлэнх олонх нь борлуулалтыг өсгөхөд чиглэн ажиллаж байна. 2024 онд 28.9 тэрбум төгрөгийн борлуулалтын орлогын төлөвлөлт хийгдсээр 23.6 тэрбум төгрөг нь биелж, борлуулалтын гүйцэтгэл 81 хувьд хангагджээ. Энэхүү гүйцэтгэлийг 2023 онтой харьцуулахад борлуулалт 18 хувиар өсөж, 3.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг: Савласан усны өртгийн 77 орчим хувийг шууд материалын зардал буюу түүхий эд материалын өртөг, 23 орчим хувийг үйлдвэрийн нэмэгдэл зардал болон шууд хөдөлмөрийн зардал эзэлж байсан бол 2019 онд 330 мл, 500мл савлагаанд ашиглагддаг хуруу савыг 26 граммаас 18 грамм, 4.5 литр савлагаанд ашиглагддаг хуруу савыг 110 граммаас 85 грамм, 4.5 литр савлагаанд ашиглагддаг бөглөөг 45 граммаас 38 грамм, 2021 онд 1.5 литр савлагаанд ашиглагддаг 36 грамм хуруу савыг 35.1 грамм, 2023 онд 500 мл савлагаанд ашиглагддаг хуруу савыг 18 граммаас 17.5 грамм болгон тус тус хөнгөрүүлснээр 3 жилийн хугацаанд жилд 120 орчим тонн хуванцар хэмнэх боломж бүрдсэн. Үүний үр дүнд 2024 онд борлуулсан бүтээгдэхүүний өртгийн 59.5 хувийг шууд материалын зардал, 40.5 хувийг үйлдвэрийн нэмэгдэл зардал болон шууд хөдөлмөрийн зардал бүрдүүлж байна. Сүүлийн 5 жилийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг, борлуулалтын орлогын харьцааг харахад 2020 оны 66.7 хувиас тасралтгүй буурсаар 2024 онд 49.3 хувьд хүрчээ. Тус харьцаа 2021 онд 61 хувь байсан бол 2023 онд 51 хувь болж 10 нэгж хувиар огцом буурсан нь ХБНГУ-ын алдарт Krone брэндийн бүрэн автомат 20000 лонх/цагийн хүчин чадалтай сав үлээх, савлах, багцлах цогц систем бүхий тоног төхөөрөмжийг суурилуулж, үйлдвэрийн хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлсний шууд үр дүн юм.

Маркетинг: Аудитлагдсан 2019-2023 оны тайлангуудаас харахад борлуулалт, маркетингийн үйл ажиллагааны төсөв 18-44 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байв. Эм Жи Эл Акуа компанийн маркетингийн төсөв 2024 онд хагас тэрбум төгрөгт хүрч, маркетингийн үйл ажиллагааны хүрээнд “Байртай бөглөө”, “Choose and Win” зэрэг “Худалдааны маркетинг”, “Брэндийн маркетинг”-ийн хөтөлбөрүүд хэрэгжлээ. Эдгээр хөтөлбөрүүдийн үр дүнд 2024 оны эхний 9 сарын байдлаар дунджаар 78 хувийн гүйцэтгэлтэй байсан борлуулалтын тоо хэмжээ 10-12 саруудад дунджаар 93 хувийн гүйцэтгэлтэй болж нэмэгдэн нийт 4,520 мянган ширхэг ус борлогджээ. Энэ нь 2023 онтой харьцуулахад 119 хувийн өсөлтийг авчирсан байна. Борлуулалтын мөнгөн дүнгийн хувьд 2024 оны эхний 9 сарын байдлаар борлуулалтын орлогын гүйцэтгэл дунджаар 82.4 хувь байсан бол маркетингийн хөтөлбөр хэрэгжсэнээр сүүлийн гурван сарын хугацаанд тус гүйцэтгэл дунджаар 98.2 хувь болж өсжээ. Түүнчлэн Facebook хандалтын тоо давтагдсан тоогоор 15.9 сая, дагагчдын тоо 11.8 мянгад хүрээд байна. Эндээс харахад маркетингийн хөтөлбөрүүд борлуулалтын орлогыг өсгөхөд бодитой дэмжлэг үзүүлсээр байна.

Хүний нөөц: Монгол улсын хөдөлмөрийн зах зээлд гарч буй ажиллах хүчний хомсдол 2024 онд Эм Жи Эл Акуа ХК-нд мэдэгдэхүйц нөлөөллөө. Эм Жи Эл Акуа ХК нь хүний нөөцийн

бодлогоороо жил бүрийн 1-2 саруудад ажиллагсдын цалинг өсгөсөөр ирсэн. 2024 онд нийт ажилтнуудын цалинг 10 хувиар өсгөсөн ч хүний нөөцийн орох, гарах урсгал тогтворгүй хэвээр байсаар байна. Үүнтэй холбоотойгоор үндсэн шалтгааныг олж тогтооход чиглэсэн хүний нөөцийн албанаас хийсэн судалгааны үр дүнгээс үзэхэд 37 хувь нь цалин хөлс хангалтгүй, 27 хувь нь улирлын чанартай ачааллыг даахгүй, 15 хувь нь сахилгын зөрчлийн улмаас ажлаас гарчээ. Тус судалгаанаас харахад цалингаас гадна алба хоорондын уялдаа холбоог хангах, холбогдох журмын зохицуулалтыг хийх, ажлын орчин нөхцөлийг сайжруулах, цалин урамшууллын тогтолцоог шинэлэх зэрэг хүлээгдэж буй ажлуудыг хийснээр хүний нөөцийн эргэц буурах гол хөшүүрэг болно гэж үзэж байна.

Үйлдвэрлэл: Эм Жи Эл Акуа ХК нь 2016 онд 170 гаруй жилийн түүхтэй, сав баглаа боодлын салбарт дэлхийд тэргүүлэгч Франц улсын Sidel группийн дэвшилтэд тоног төхөөрөмж бүхий бүрэн автомат компьютер удирдлагын системтэй хуруу сав үлээх төхөөрөмжийг, 24 жилийн түүхтэй, сав баглаа боодлын техник технологийн салбарт Ази тивд тэргүүлэгч БНХАУ-ын Techlog Packing Machinery компанийн жижиг болон 4.5л бүхий бүрэн автомат савлах, багцлах цогц шугамуудыг тус тус суурилсан. 2023 онд 70 жилийн туршлагатай ХБНГУ-ын алдарт Krones брэндийн сав үлээх, савлах, багцлах цогц систем бүхий бүрэн автомат компьютерын удирдлагын системтэй төхөөрөмжийг суурилуулсан. Эм Жи Эл Акуа ХК-ий 1 литр савлагаатай усыг үйлдвэрлэх хүчин чадал нь цагт 20 тонн, хоногт 480 тонн, сард 14,400 тонн, жилд 172,800 тонн гэж тодорхойлж болно. Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж, тоног төхөөрөмжийг үе шаттай шинэчилсний үр дүнд 0.2л, 0.33л, pH8.5-тай 0.33л, 0.33л бор, 0.4л, 0.5л, pH8.5-тай 0.5л, 0.8л, 1.5л, 4.5л зэрэг нийт 10 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Эдгээр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шугамын гологдол бүтээгдэхүүний нэр төрлөөс хамаарч 0.41-1.82 хувийн хооронд хэлбэлзэж байна.

Тогтвортой хөгжил: Эм Жи Эл Акуа ХК нь БОНЗ-ын тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд байгальд ээлтэй, боломжийн үнэтэй, тогтвортой бизнес хөгжил гэсэн гурван үндсэн зарчмыг баримталдаг. Хуруу савны граммыг хөнгөрүүлснээр 0.5 мл савлагаанаас жилд 93 тонн хуванцар, 1.5 литр савлагаанаас жилд 4 тонн хуванцар, 4.5 литр савлагаанаас жилд 67 тонн хуванцар, жижиг савлагаануудаас жилд 10 тонн хуванцар хэмнэсэн болохыг материалын менежментийн хүрээнд тооцоолжээ. Эм Жи Эл Акуа ХК 2024 онд 24 тонн хуванцарын хэмнэлт гаргажээ.

Сайн засаглалын хүрээнд: Эм Жи Эл Акуа ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2024 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулагдаж, тус хурлаар ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг хэлэлцэн баталсан. Шинээр бүрэлдсэн ТУЗ нь танхимаар 5, цахимаар 3 нийт 8 удаа хуралдсан. Танхимаар 2 удаа буюу 2024 оны 10 сарын 16, 2025 оны 1 сарын 30-ны өдрүүдэд хуралдахдаа 2025 оны бизнес төлөвлөгөөнөөс гадна гүйцэтгэх удирдлагуудын үйл ажиллагааны тайланг хэлэлцэж цаашид компанийн үйл ажиллагаа, хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн борлуулалт, ашигт ажиллагаа болон үйл ажиллагааны тоон зорилтуудыг хэрхэн хангах талаар тодорхой бодлогын чиглэлийг өгч ажиллалаа.

Санхүүгийн үр дүн: Эм Жи Эл Акуа ХК нь 2024 онд санхүүгийн хувьд 2023 оны үр дүнг давуулан биелүүллээ. 2024 оны балансын голлох үзүүлэлтээс харахад эргэлтийн хөрөнгө 29.4 тэрбум буюу 76 хувиар өссөн бол богино хугацаат өр төлбөр 6 тэрбум буюу 48 хувиар

буурсан байна. Баланс дээр гарсан энэхүү өөрчлөлтийн үр дүнд төлбөр түргэн гүйцэтгэх чадвар эрс сайжирлаа. Эргэлтийн хөрөнгийн өсөлт нь бүрэлдэхүүний хувьд илүү чанаржиж бусад авлага, бараа материал, урьдчилж төлсөн зардлын эзлэх жингүүд нэмэгджээ. Үүний үр дүнд авлага цуглуулах дундаж хугацаа 25 хоног, бараа материалын дундаж хугацаа 95 хоног гэж тооцогдсон нь 2023 онтой харьцуулахад өөрчлөлт нь харьцангуй бага байна. Эм Жи Эл Акуа ХК-ий нийт хөрөнгө 2024 онд 36 хувиар өсөж 46.1 тэрбум төгрөгт хүрэв. Тус компанийн эзний өмч 5 жилийн өмнө буюу 2020 онд 2.2 тэрбум төгрөг байсан бол 2021 онд 234 хувь, 2022 онд 73 хувь, 2023 онд 78.8 хувь, 2024 онд 79 хувийн огцом өсөлтүүдийг хийсний үр дүнд 40 тэрбум төгрөгт хүрээд байна. Ингэснээр богино хугацаат өр төлбөр үүсгэлгүйгээр өөрийн хөрөнгөөрөө үйл ажиллагааныхаа эрсдэлийг хангалттай хэмжээнд даах чадавхтай болжээ. Эм Жи Эл Акуа ХК-ий үйл ажиллагааны зардал 7.5 тэрбум төгрөгт хүрч 46 хувиар өссөн ч үйл ажиллагааны ашгаа 2023 оны түвшинд хадгалжээ. Харин цэвэр ашгийн хувьд 2023 онтой харьцуулахад 2024 онд 31 хувийн өсөлт үзүүлж 3.4 тэрбум төгрөгийн ашиг олжээ. Эдгээрийн үр дүнд нийт ашгийн марж 51 хувь, цэвэр ашгийн марж 14.4 хувь, нийт хөрөнгийн өгөөж 8.5 хувьтай гарснаар 2023 оны харгалзах түвшинд давж биелжээ. Үүн дээр нэмэгдэж үйл ажиллагааны марж 19 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 11 хувьтай гарсан нь ашиг ажиллагааны хувьд харьцангуй өндөр гүйцэтгэлийг үзүүлсэн. Компанийн хувьцааны ханш 2024 оны 6 сарын 3 буюу арилжаалагдсан эхэлснээс хойш багадаа 162 төгрөг, ихдээ 191 төгрөгт хүрч 2024 оны эцэс хүртэл харьцангуй тогтвортой байлаа. Эм Жи Эл Акуа ХК-ий 2024 оны санхүүгийн гүйцэтгэлийн үр дүнд зах зээлийн үнэ, ашгийн харьцаа (P/E ratio) 17.6, зах зээлийн үнэ, эздийн өмчийн харьцаа (P/B ratio) 1.5, компанийн үнэлгээ, үйл ажиллагааны ашгийн харьцаа (EV/EBITDA ratio) 13.2 гэж тогтоогдлоо.

Дээр дурдсан бүх үр дүнгийн тайлбарууд дээр үндэслэн Эм Жи Эл Акуа ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын багийг 2024 оны үйл ажиллагааны зорилтоо амжилттай биелүүлсэн гэж үзэж байна.

ЭМ ЖИ ЭЛ АКУА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ




Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой мэдээлэл:

2025 оны бизнес төлөвлөгөө





Бүтэц

2025 онд Эм Жи Эл Акуа компани нийт 247 хүний нөөцтэй, дараах бүтцээр ажиллана.



Санхүүгийн төлөвлөгөө

Тэрбум төгрөг




Борлуулалтын төлөвлөгөө /сараар/

2025 оноос эхэлж борлуулалтын албаны төлөвлөгөөг мөнгөн дүнгээр тавьж эхэлсэн ба өмнөх жилүүдэд тоо ширхгийн төлөвлөгөөтэй байсан.

Энэ онд 39,140,000,000₮ төлөвлөгөө тавьсан нь өмнөх 2024 оны 23,679,000,000₮ мөнгөн дүнгийн гүйцэтгэлээс 65%-ийн өссөн төлөвлөгөө тавьсан.

- 1-р улиралд 4,341,374,228₮ төлөвлөгөө нь өмнөх оны 3,372,449,359₮ мөнгөн дүнгийн гүйцэтгэлээс 11% өссөн төлөвлөгөө
- 2-р улиралд 13,036,532,952₮ төлөвлөгөө нь өмнөх оны 7,521,995,274₮ мөнгөн дүнгийн гүйцэтгэлээс 33% өссөн төлөвлөгөө
- 3-р улиралд 15,133,437,544₮ төлөвлөгөө нь өмнөх оны 8,224,933,178₮ мөнгөн дүнгийн гүйцэтгэлээс 38% өссөн төлөвлөгөө
- 4-р улиралд 7,088,070,399₮ төлөвлөгөө нь өмнөх оны 4,485,501,818₮ мөнгөн дүнгийн гүйцэтгэлээс 18% өссөн төлөвлөгөөг тус тус өсгөж тавьсан.



Борлуулалтын сувгийн төлөвлөгөө

Өмнөх 2024 оны гүйцэтгэлээс хамаарч дараах байдлаар мөнгөн дүнгийн төлөвлөгөөг 2025 онд биелүүлнэ.

41%

GENERAL TRADE

-17.316.836.427 MNT
-14.793.175 QTY

19%

MODERN TRADE

- 7.471.409.760 MNT
- 8.373.237 QTY

2%

SUB REGION

- 1.046.438.496 MNT
- 881.135 QTY

23%

REGIONAL

- 10.104.254.106 MNT
- 9.998.083 QTY

12%

OPEN MARKET

- 5.141.932.226 MNT
- 4.804.020 QTY

3%

EATING DRINK

- 1.252.709.790 MNT
- 1.150.347 QTY

- General trade - Суваг нь нийт төлөвлөгөөний 41% буюу 17,316,836,427₮
- Modern trade - Суваг нь нийт төлөвлөгөөний 19% буюу 7,471,409,760₮
- Open market - Суваг нь нийт төлөвлөгөөний 12% буюу 5,141,593,226₮
- Region - Суваг нь нийт төлөвлөгөөний 23% буюу 10,104,254,106₮
- Sub region - Суваг нь нийт төлөвлөгөөний 2% буюу 1,046,438,496₮
- Eating drink - Суваг нь нийт төлөвлөгөөний 3% буюу 1,252,709,790₮

Орон нутгийн борлуулалт

2025 онд өмнө хамраагүй Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Хөвсгөл, Өвөрхангай, Дундговь, Сүхбаатар аймгуудад дээр шинээр томоохон харилцагч нээж гэрээтээр хамтран ажиллана.

200 гэрээтээр /LYTD +27%/ дамжуулан 4395 харилцагчдад бүтээгдэхүүнээ түгээнэ.

Энэ онд 700 км доторх аймгуудад шууд хүргэлт, 700 км-ээс дээш аймгуудад гэрээт тээврийн хэрэгслээр хүргэлт хийнэ.

Баянхонгор, Архангай, Хэнтий, Орхон аймгуудад дундын агуулахаар дамжуулан борлуулалт хийнэ.

Маркетингийн төлөвлөгөө

Брэнд маркетинг

Брэндийн үнэ цэнийг нэмэгдүүлэх

Voyage брэндийн үнэнч хэрэглэгчдийг урамшуулах, шинэ хэрэглэгчдийг бий болгох зорилгоор дижитал платформд суурилсан урамшууллын системийг бий болгоно.

“Тэнцвэртэй өөрийгөө хайрлая”- нийгмийн нөлөөллийн маркетингийн компанит ажил хэрэгжүүлж Voyage брэндийг үнэ цэнийг нэмэгдүүлнэ.

- Voyage цэвэр ус Бумбатын рашааны гүний ус ашигладгийг онцлон брэндийн давуу чанарыг бий болгох контент бүтээж таниулах
- Сошиал медиа болон бусад сурталчилгааны сувгийн зорилтот - 50,000,000 үзэлттэй байх
- FB followers - 25,000 хүргэх

Худалдааны маркетинг

Дараах календарийн дагуу харилцагчийн хамтын ажиллагааны хүрээнд худалдааны маркетингийн ажлууд хийгдэнэ.

- CVS - 4-6 сар, 12 сард харилцагчийн хамтарсан хөтөлбөр
- General trade - 4-10 саруудад өрөлтийн хөтөлбөр
- General trade - 4-9 ТОП харилцагчийн хөтөлбөр
- Open market – 5-6 саруудад багцын хөтөлбөр
- HORECA – шинэ харилцагчийн хамралт +1000 харилцагч
- Орон нутаг – орон нутгийн гэрээт +43 харилцагч

Үйлдвэрлэлийн төлөвлөгөө

Тус онд 40.6 сая ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Үүнд:


- Tech-Long шугам: 38.812.500 литр, 8.625.000 ширхэг
- Кронес шугам: 10.260.940 литр, 24.726.840 ширхэг
- Sidel шугам: 7.313.846 литр, 7.248.564 ширхэг

Түгээлтийн төлөвлөгөө

Тус онд түгээлтийн алба 89 ажилтантайгаар Улаанбаатарт 40 машин, орон нутагт 2 машинтайгаар 55,8 тонн бүтээгдэхүүнийг 6600 харилцагчид түгээн ажиллана.

Ханбогд төсөл

2025 онд Өмнөговь аймгийн Ханбогд суманд салбар үйлдвэр байгуулна.



Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой мэдээлэл:

Компанийн ногдол ашгийн бодлого, 2025 оны ногдол ашгийн шийдвэр



**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 2 сарын 12

№ 7/33

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дүгээр зүйлийн 46.1, 46.5 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, “Эм жи эл акуа” ХК-ийн дүрмийн 6.4 дэхь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

4. “Эм жи эл акуа” ХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгийн дүнгээс 70% хувиар буюу 2,393,776,441.73 төгрөгийг мөнгөн хэлбэр тооцож, нэгж хувьцаанд 7.31 (долоон төгрөг гучин нэгэн мөнгө) төгрөгийн ногдол ашиг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
5. Ногдол ашиг хүртэх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2025 оны 02 сарын 28 өдрөөр тогтоож, ногдол ашгийг 2025 оны 04 сарын 30-ны өдрийн дотор төлөхөөр тогтоосугай.
6. Тогтоолын хэрэгжилтийг хангуулж, төлбөр тооцоо хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулахыг гүйцэтгэх захиралд /Х.Тэгшээ/, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудит эрсдлийн хороонд /Ч.Анхбаяр/ тус тус даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



С. АЛТАНТУЯА

Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой мэдээлэл:

ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

“Эм Жи Эл Акуа” ХК-ийн бүхэн Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн материалыг 2025.04.01-ний өдрийг хүртэл ХЭХ зохион байгуулах комисс болон investor@mglacqua.mn хаягаар хүлээн авна.

Хувьцаа эзэмшигчид та бүхэн Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулгатай 2025.04.05-ны өдрөөс эхлэн <https://agm.mn/> цахим системээр дамжуулан танилцах болон урьдчилан саналаа өгөх боломжтой.

ЕРДИЙН ГИШҮҮД

 <p style="text-align: center;">С.Алтантуяа</p>	 <p style="text-align: center;">Х.Тэгшээ</p>	 <p style="text-align: center;">Б.Ундрал</p>
<p>Туршлага:</p> <p>2024 оноос Эм жи эл ауга ХК ТУЗ ердийн гишүүн 2018 оноос Ти эм эл ХХК, Дэд захирал 2017-2018 Говь ХК, Оёмол үйлдвэрийн дарга 2015-2017 Говь ХК, Маркетингийн албаны дарга 2005-2014 М- Си-Эс Кока Кола ХХК, Маркетингийн ахлах менежер</p> <p>Боловсрол:</p> <p>2011-2013, МУ, Удирдлагын академи, Бизнесийн удирдлагын магистер 1999-2005 БНХАУ, Бээжин хотын ОУ-ын их сургууль, ОУ худалдааны эдийн засаг (Бакалавр) 2003 АНУ, Utah Valley university /Оюутан солилцооны хөтөлбөр/</p>	<p>Туршлага:</p> <p>2024 оноос Эм жи эл ауга ХК ТУЗ ердийн гишүүн 2006 оноос Ти эм эл ХХК үүсгэн байгуулагч захирал 2021 оноос ТЖТБ ХХК, Ерөнхий захирал 2024 оноос ТУЗ-ын гишүүн</p> <p>Боловсрол:</p> <p>1999-2003 БНХАУ, Өвөр Монголын Их Сургууль /Inner Mongolia University/, Химич /Бакалавр/</p>	<p>Туршлага:</p> <p>2024 оноос Эм жи эл ауга ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн 2018 оноос “Ти Эм Эл” ХХК-д Хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирал 2008-2016 онд Голомт банк ХХК-д Эдийн засагч болон харилцааны менежер</p> <p>Боловсрол:</p> <p>2023 оноос МУИС, Санхүү менежмент (Магистрант) 2005-2008 Мандах бүртгэл дээд сургууль, Нягтлан бодох бүртгэл (Бакалавр)</p>

 <p style="text-align: center;">О.Сансар</p>	 <p style="text-align: center;">Л.Билгүүн</p>	 <p style="text-align: center;">М.Дөлгөөн</p>
<p>Туршлага:</p> <p>2024 оноос Эм жи эл аука ХК ТУЗ гишүүн 2023 оноос “Ти Эм Эл” ХХК-д Санхүүгийн албаны дарга 2020 оноос Ньюгор ХХК-д санхүүгийн албаны дарга 2020 оноос “ТЖТБ” ХХК-д Санхүүгийн менежер 2019-2022 онд “Ти Эм Эл” ХХК-д санхүүгийн менежер 2015-2019 онд Тайшэн Девелопмент ХХК-д нягтлан бодогч</p> <p>Боловсрол: 2011-2015 Liaoning university, Нягтлан бодох бүртгэл (Бакалавр)</p>	<p>Туршлага:</p> <p>2024 оноос Эм жи эл аука ХК ТУЗ ердийн гишүүн 2022 оноос одоог хүртэл “Инвескор Капитал ҮЦК” ХХК-д Гүйцэтгэх захирал 2020-2021 “Смарт Брокерс” ХХК - д Гүйцэтгэх захирал 2021 онд “Даатгалын зуучлагчдын холбоо” ТББ-д Удирдах зөвлөлийн гишүүн 2017-2020 онд Голомт банкинд Корпорэйт менежер 2014-2017 онд УБ хотын банк-д Харилцааны менежер</p> <p>Боловсрол: Монгол Улсын Их Сургууль, Эдийн засгийн сургууль: Банкны менежмент бакалавр</p>	<p>Туршлага:</p> <p>2024 оноос Эм жи эл аука ХК ТУЗ ердийн гишүүн 2024 он: Гүйцэтгэх захирал /Триллиум ХХК/ 2024 он: Бизнес хөгжүүлэлтийн менежер /Мед Монгол ХХК/ 2021 он: Англи хэлний багш /Гэгээ сургууль/ 2020 он: Борлуулалтын мэргэжилтэн /Занаду Вайнес ХХК/ 2017-2018 он: Менежерийн туслах /Цэцэг зочид буудал/ 2016 он: Ресейпшн /Цэцэг зочид буудал/</p> <p>Боловсрол: Мельбурны их сургууль: Анагаах ухааны сургууль, Шинжлэх ухааны бакалавр, Хүний анатоми / биологи</p>

ХАРААТ БУС ГИШҮҮД

 <p>Д.Басандорж</p>	 <p>С.Санасэр</p>	 <p>Ч.Анхбаяр</p>
<p>Туршлага:</p> <p>2024 оноос Эм жи эл аука ХК ТУЗ хараат бус гишүүн 2005-2023 Усны нөөцийн менежментийн судалгааны төвийн захирал 2021-2022 ШУТИС, Байгаль орчин Инженерийн тэнхимийн эрхлэгч 2013-одоо Монголын усны туншлэл ТББ, Тэргүүн 1996-2000 Байгаль орчны яам, Төрийн нарийн бичгийн дарга 1984-1994 ШУТИС, Багш</p> <p>Боловсрол:</p> <p>2002 ОХУ, Барилга Инженер Архитектурын Их Сургууль, Техникийн шинжлэх ухааны доктор (PhD) 1984 ОХУ, Усны Инженер Технологийн их сургууль, Хот суурин газрын усан хангамжийн магистр (MSc)</p>	<p>Туршлага:</p> <p>2023-одоо Эм Жи Эл Аука ХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн 2022-одоо Аргентин Монголын бизнесийн зөвлөл ТББ, УЗ-ийн дарга 2007-одоо МУИС, Бизнесийн сургууль, ахлах багш (PhD) 2022-2023 Волтам ХХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн 2015-2017 Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз, Үндэсний зөвлөлийн гишүүн 2006-2007 Сентр Шевролет (АНУ), Худалдааны зөвлөх</p> <p>Боловсрол:</p> <p>2021–2023 МУИС, Бизнесийн сургууль, Бизнесийн удирдлагын доктор (PhD) 2017–2018 АНУ, Харвардын их сургууль, Төрийн удирдлагын магистр (MPA) 2004-2006 АНУ, Калифорнийн Олон улсын их сургууль, Шинжлэх ухааны магистр (MSc) 1998-2002 МУИС, Эдийн засгийн сургууль, Бизнесийн удирдлагын бакалавр (BBA)</p>	<p>Туршлага:</p> <p>2024 оноос Эм жи эл аука ХК ТУЗ хараат бус гишүүн 2021–одоо МУИС, Дэд профессор 2018-2021 МУИС, Багш 2016–2017 АХБ төсөл, Үндэсний зөвлөх 2012-2015 Мандал даатгал, Ахлах эрсдлийн шинжээч 2010-2012 Хадгаламжийн банк, Ахлах санхүүгийн шинжээч 2009-2010 Тээвэр хөгжлийн банк, Эрсдлийн удирдлагын газар, захирал 2008-2009 Анод банк, Ахлах судалгааны мэргэжилтэн</p> <p>Боловсрол:</p> <p>2016-2018 МУИС, Бизнесийн удирдлага доктор (PhD) 2012-2014 МУИС, Хэрэглээний математик магистр (MSAM) 2001-2006 СЭЗДС, Бизнесийн эдийн засгийн бакалавр (BBE)</p>

Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой мэдээлэл:

2025 ТУЗ төсөв

Үндсэн цалин	354,000,000
Нөхцөлт цалин	24,000,000
ТУЗ үйл ажиллагааны төсөв	20,000,000
Борлуулалт төлөвлөгөөний гүйцэтгэлийн урамшуулал	330,000,000
Нийт	728,000,000

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ГАРАХ
ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД**

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 23
хот

№ 1

Улаанбаатар

**“Эм Жи Эл Акуа” ХК-ийн 2024 жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн
тайланд
хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, компанийн дүрмийн 7.8.3 дэхь заалтуудыг тус тус удирдлага болгон 2025 оны 04 сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Эм Жи Эл Акуа ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Хавсралт 1 ёсоор баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

С. САНАСЭР

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 23
хот

№ 5

Улаанбаатар

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.13 дахь заалт болон 2025 оны 04 сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг нийт ** төгрөгөөр баталсугай.
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

С. САНАСЭР

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 23
хот

№4

Улаанбаатар

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дүгээр зүйлийн 62.1.7 дахь заалт болон 2025 оны 04 сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд олонхийн санал авсан:

Ердийн гишүүдэд:

1. **
2. **
3. **
4. **
5. **
6. **

Хараат бус гишүүдэд

1. **
2. **
3. **

нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА

С. САНАСЭР

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн Т/38 дүгээр тогтоолын
Хавсралт №4

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Регистрийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо

Бүртгэсэн /Үнэт цаасны компани /

Брокерийн овог нэр

“Эм Жи Эл Акуа” ХК-ийн **Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал** 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 10:00 цагт <https://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр хуралдана.

Саналын хуудас бөглөх заавар: **Дараах хэлэлцэх асуудлуудыг ЕРДИЙН АРГААР санал хураана.**

Ердийн аргаар саналаа өгөхөд асуудал бүрээр “зөвшөөрсөн”, “таггалзсан”, “түдгэлзсэн” аль нь болохыг тэмдэглэнэ.

№	ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Таггалзсан	Түдгэлзсэн	Санал
1.	“Эм Жи Эл Акуа” ХК-ийн 2024 жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ -ийн дүгнэлтийг хэлэлцүүлж батлах тухай	Тогтоол №1				
2.	Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг танилцуулах тухай					
3.	Компанийн ногдол ашгийн бодлого, 2025 оны ногдол ашгийн шийдвэрийг танилцуулах тухай					
5.	ТУЗ-ийн 2025 оны төсөв батлах тухай	Тогтоол №5				

Брокер: /
/ гарын үсэг, тэмдэг /

Хувьцаа эзэмшигч: /
/ гарын үсэг /

Саналын хуудсыг **хүчинтэйд** тооцов:/ /

Саналын хуудас **хүчингүйд** тооцсон бол шалтгаан:.....

.....

2025 оны сар өдөр

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн Т/38 дүгээр тогтоолын
“Хавсралт №4”

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Регистрийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Эзэмшиж буй хувьцааны төрөл тоо

Кумулятив хувьцааны тоо:

Бүртгэсэн /Үнэт цаасны компани /

Брокерийн овог нэр

“Эм Жи Эл Акуа” ХК-ийн **Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал** 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 10:00 цагт <https://agm.mn/> холбоосоор дамжуулан цахим хэлбэрээр хуралдана.

Саналын хуудас бөглөх заавар: **Дараах хэлэлцэх асуудлуудыг КУМУЛЯТИВ АРГААР санал хураана**

Кумулятив саналын тоо нь таны эзэмшиж байгаа энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.

Жишээ нь: Та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл нийт 100*9=900 кумулятив саналын эрхтэй болно. Та нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг эсвэл хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох			
ТУЗ-ийн ердийн гишүүн:	Санал авах арга	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1.	Кумулятив	Тогтоол №4	
2.			
3.			
4.			
5.			
6.			
ТУЗ-ийн хараат бус гишүүн:			Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1.			
2.			
3.			

Брокер Гарын үсэг

Хувьцаа Эзэмшигч Гарын үсэг

2025 сар.....өдөр

Саналын хуудсын хүчинтэйд тооцон тоолсон Тооллогын Комиссын дарга

Комиссын Гишүүн

Хүчингүйд тооцсон бол шалтгаан

.....

.....

САНАЛЫН ХУУДСЫГ БӨГЛӨХ САНАМЖ:

Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө

1. Саналыг ердийн аргаар тоолох асуудалд:

- Тухайн асуудалд зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэсэн аль нэгд нь ✓ эсвэл + тэмдгээр санал аа өгнө.
- Засварласан, балласан, эсвэл болон аль нэг саналыг бөглөөгүй бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.

2. Саналыг кумулятив аргаар тоолох асуудалд:

- ТУЗ-ийн гишүүдэд санал өгөхдөө кумулятив аргаар санал хураана
- Хувьцааны нэгж тутамд ТУЗ-ийн гишүүнийг сонгох 1 саналын эрх байна. Хувьцаа эзэмшигч саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно.

- Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.
- Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамаарна.

ТЭМДЭГЛЭЛ